

1. Ном захиалгын мэдэгдэл



**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААН, СПОРТЫН ЯАМ**

14200 Улаанбаатар хог, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу 44, Засгийн газрын III байр,
Утас: 26-22-27, Факс: (976-11) 323589
E-mail: info@mecss.gov.mn, http://www.mecss.gov.mn

2018.09.11 № 4/10637

танай _____-ны № _____-т

“Боловсролын чанарын шинэчлэл”
төслийн хүрээнд бага ангийн номын
санд зориулан каталоогоос ном
сонгох тухай

Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр БСШУСЯ-наас хэрэгжүүлж буй “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн хүрээнд аймгийн төв ба сумын 500 сургуулийн I-V ангийн ангийн номын санг шинэ ном, бүтээлээр сэлбэж баяжуулах зорилгоор хүүхдийн номын каталогийг боловсруулан та бүхэнд “Боловсролын салбарын мэдээллийн систем”-ээр хүргүүлж байна. Энэхүү каталоогт бага ангийн багш нарын баг хүүхдийн шилдэг бүтээлээс сонгон оруулсан бөгөөд бага ангийн багш, сурагчид бие даан ном сонгох боломжийг олгох юм.

Танай сургуульд бага бүлгийн тооноос хамааруулан бүлэг бүрт ном авах санхүүжилтийн эрх буюу тодорхой төсөв оноогдож байгаа ба оноогдсон төсвийн тухай мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна. Каталог ба захиалгын хуудсыг “Боловсролын салбарын мэдээллийн систем”-ээр дамжуулан илгээж, захиалгыг онлайнаар хүлээн авна.

Сурагчдынхаа мэдлэг боловсролд нэн хэрэгцээтэй, оюун ухааныг нь тэлэх, хүсэл сонирхолд нь нийцэхүйц ном бүтээлийг төслөөс хуваарилсан төсөвт багтаан сонгох энэхүү ажилд сурагч, багш, эцэг эхийн төлөөллийг идэвхтэй оролцуулахыг үүгээр мэдэгдэж байна.

Номын захиалгаа хүүхдийн номын каталог, номын захиалгын маягтыг ашиглан зааврын дагуу 21 хоногт багтаан 2018 оны 9 дүгээр сарын 28-ны дотор БСМС-ээр илгээнэ үү.

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГА

Т.НЯМ-ОЧИР



09 15166